

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2018 ОНЫ 5 ДУГААР ХУРАЛДААН**

Хуралдаан 2018 оны дөрөвдүгээр сарын 6-ны өдрийн 17 цаг 30 минутад эхэлж, 18 цаг 28 минут хүртэл Засаг даргын Тамгын газрын даргын өрөөнд болж, нийт 52 минут үргэлжлэв.

№	Хэлэлцэх асуудлын төлөвлөгөө	Шийдвэр
1	<p>Дундговь аймгийн нутгийн захиргааны байгууллагуудын захиалгын дагуу төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөөцөөс нөхөх тухай</p> <p>-Аймгийн ИТХ-ын ажлын албаны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан мэргэжилтний албан тушаалд нэр дэвшүүлэх тухай</p> <p>-Нийгмийн даатгалын хэлтсийн Эрдэнэдалай сум хариуцсан байцаагчийн албан тушаалд нэр дэвшүүлэх тухай</p>	<p>Аймгийн ИТХ-ын ажлын албаны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан ажилтны албан тушаалд Төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцийн жагсаалтад 2016 оны 11 дүгээр сарын 28 –ны өдөр бүртгэгдсэн Жамбал овогтой Түмэндэлгэрийг, Нийгмийн даатгалын хэлтсийн Эрдэнэдалай сум хариуцсан байцаагчийн албан тушаалд Төрийн албаны зөвлөлийн 2018 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 03 дугаар тогтоолоор Төрийн жинхэнэ албанд анх орох иргэдийн нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн Эрдэнэбилэг овогтой Өлзиймааг тус тус нэр дэвшүүлэхээр шийдвэрлэж, холбогдох материалыг тухайн багууллагуудад хүргүүлэхээр болов.</p>
2	<p>Сайнцагаан сумын Санхүүгийн албаны даргын сонгон шалгаруулалтын дүнгийн тухай</p>	<p>Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албаны даргын албан тушаалын сонгон шалгаруулалтад Сүхбаатар овогтой Отгонбямба 57.95 оноо авч, 77.27 хувьтай дүгнэгдэж тэнцсэн тул түүнийг тухайн албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг баталж холбогдох материалыг хүргүүлэхээр шийдвэрлэв.</p>

САЛБАР ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА